



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

MONTHLY BULLETIN OF STATISTICS

2018/12



www.nso.mn govisumber.nso.mn www.1212.mn



ГАРЧИГ

- I. Нийгмийн байдал.....
- II. Нийгмийн даатгал, халамж.....
- III. Эрүүл мэнд
- IV. Гэмт хэрэг
- V. Үнэ.....
- VI. Төсөв.....
- VII. Хөдөө аж ахуй
- VIII. Аж үйлдвэр
- IX. Цаг уур.....
- Хавсралт.....



Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал



I. Нийгмийн байдал


I.1 Ажил хайгч иргэд

Тайлант сарын эцэст Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэд 192, үүнээс ажил хайгч ажилгүй иргэдийн тоо 137 байгаагийн 67 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 147 буюу 51.8 хувиар, өмнөх сараас 35 буюу 20.3 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Арванхоёрдугаар сард Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт 35 ажлын байрны захиалга иржээ.

Тайлант сард 28 иргэн ажилд зуучлагдсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 75.0 хувиар их байна.

Зураг I.1. Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэн, жил бүрийн тайлант сарын эцэст



Ажил хайгч ажилгүй иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл 15-24 насны 32, 25-34 насны 45, 35-44 насны 26, 45-54 насны 24, 55 түүнээс дээш насны 10 иргэн байна.


I.2 Ердийн хөдөлгөөн

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2018 оны эхний 12 сарын байдлаар 468 эх амаржиж, 469 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 74 буюу 18.8 хувиар, төрсөн хүүхдийн тоо 69 буюу 17.3 хувиар тус тус өссөн байна.

Нас баралт 84, бүртгүүлсэн гэр бүл 86, цуцалсан гэр бүл 17 байгаа нь өмнөх оны мөн үеэс цуцалсан гэр бүл 17 буюу 2 дахин, нас баралт 16 буюу 16.0 хувиар буурч, бүртгүүлсэн гэр бүл 14 буюу 19.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд 9 хүүхэд үрчлэгдсэн. Шилжилт хөдөлгөөний мэдээгээр 563 хүн шилжин ирж, 466 хүн шилжин явсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал шилжин ирэлт 12.2 хувиар, шилжин явалт 4.5 хувиар тус тус буурчээ.



Зураг I.2. Төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 12 сарын байдлаар



II. Нийгмийн даатгал, халамж

II.1 Нийгмийн даатгал

2018 оны эхний 12 сарын байдлаар нийгмийн даатгалын сангийн орлого 10935.5 сая төгрөг, зарлага 10864.7 сая төгрөг болсон байна.

Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт 136.2 хувьтай, зарлагын гүйцэтгэл 105.9 хувьтай байна.

II.2 Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2018 оны эхний 12 сарын байдлаар 7467 хүнд 1973.2 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамж хүртэгсэд 1833 хүн буюу 65.1 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж 595.0 сая төгрөг буюу 43.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 2018 оны эхний 12 сарын байдлаар 2314 хүн хамруулж 1200.1 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 997 хүн буюу 75.7 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 446.2 сая төгрөг буюу 59.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн үйлчилгээ хөнгөлөлт, тусламжид 2018 оны эхний 12 сарын байдлаар 5153 хүн хамруулж 773.1 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 836 хүн буюу 19.4 хувиар, олгосон халамж үйлчилгээ, хөнгөлөлт, тусламж 148.9 сая төгрөг буюу 23.9 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.


II.3 Дундаж цалин

Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны 12 дугаар сарын мэдээгээр 213 байгууллагын 6049 даатгуулагч иргэн, үүнээс 696 нь сайн дурын даатгуулагч байна. Ажиллагсдын дундаж цалинг аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 11 аж ахуйн нэгж, байгууллагын 476 даатгуулагчийн дундаж цалин 801.4 мянган төгрөг, төсөвт 54 байгууллагын 1841 даатгуулагчийн дундаж цалин 730.1 мянган төгрөг, 2 Хувьцаат Компаний 703 даатгуулагчийн дундаж цалин



1150.4 мянган төгрөг, 125 ХХКомпаний 2136 даатгуулагчийн дундаж цалин 1 390.5 мянган төгрөг, бусад 21 аж ахуйн нэгж байгууллагын 197 даатгуулагчийн дундаж цалин 661.4 мянган төгрөг боллоо.

Зураг II.1.Нийгмийн даатгалын даатгуулагчийн тоо, 2018 оны эхний 12 сарын байдлаар




III.Эрүүл мэнд



Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2018 оны эхний 12 сарын байдлаар 471 эх амаржиж, 2017 оны мөн үетэй харьцуулахад 55 буюу 13.2 хувиар өссөн байна. Амьд төрсөн хүүхэд 470 үүнээс 230 нь хүү, 240 нь охин байна. Өмнөх оны мөн үеэс амьд төрсөн хүүхэд 52 буюу 12.4 хувиар өссөн байна.

0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1, 1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл 2 бүртгэгдсэн байна. Эхийн эндэгдэл бүртгэгдээгүй.


Зураг III.1. Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, жил бүрийн эхний 12 сарын байдлаар



Халдварт өвчин эхний 12 сарын байдлаар 262 буюу 10000 хүн амд 150.5 хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 28 тохиолдлоор өсчээ.




Зураг III.2.Нас баралт, жил бүрийн эхний 12 сарын байдлаар



Он гарсаар давхардсан тоогоор 110.0 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 5.9 мянган хүнээр буюу 5.1 хувиар буурч, 5.1 мянган өвчтөн эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 0.3 мянган хүнээр буюу 6.0 хувиар өссөн байна.

2018 оны эхний 12 сарын байдлаар түргэн тусламжийн дуудлага 6816 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 0.3 мянган хүнээр буюу 3.9 хувиар өссөн байна.


Зураг III.3.Амьгүй төрсөн хүүхэд болон нялхсын эндэгдэл, жил бүрийн эхний 12 сарын байдлаар



IV. Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2018 оны эхний 12 сарын байдлаар 176 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5 буюу 2.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг IV.1.Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн эхний 12 сарын байдлаар






Өмнөх оны мөн үеэс нийт гэмт хэргийн тоо өсөхөд хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг болон авилгын гэмт хэрэг өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Илрээгүй гэмт хэрэг 64 байгаа нь өмнөх оны мөн үеэс 64.1 хувиар өссөн. Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 62.6 болсон нь өмнөх оны мөн үеэс 2.4 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн улмаас 107 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэс 15.7 хувиар буурсан байна.


Зураг IV.2. Гэмт хэргийн ангилал, жил бүрийн эхний 12 сарын байдлаар



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2018 оны эхний 12 сарын байдлаар 548.9 сая төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 290.8 сая төг болж, өмнөх оны мөн үеэс учирсан хохирлын хэмжээ 244.9 сая төгрөгөөр буюу 80.6 хувиар, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 80.8 сая төгрөг буюу 38.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

2018 оны эхний 12 сарын байдлаар давхардсан тоогоор 720 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 39 хүнээр буюу 5.1 хувиар буурсан байна.

Зураг IV.3. Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо жил бүрийн эхний 12 сарын байдлаар



V. Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ аймгийн хэмжээнд 2018 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 5.8 хувиар өсч, өмнөх сартай ижил түвшинд байна.

Хүснэгт V.1.Хэрэглээний үнийн индекс, 2018 оны 12 дугаар сард, бүлгийн дүнгээр

Бараа үйлчилгээний бүлэг	2018. XII	2018. XII
	2017. XII	2018. XI
Ерөнхий индекс	105.8	100.0
Хүнсний бараа, ундаа, ус	108.0	100.1
Согтууруулах ундаа, тамхи	109.9	100.4
=	=	100.9
Орон сууц, ус, цахилгаан, түлш	103.7	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	108.0	100.1
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	100.7	100.0
Тээвэр	111.0	99.5
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.1	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	120.0	100.0
Боловсролын үйлчилгээ	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	110.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	106.7	100.1

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хорооны сарын мэдээ




VI. Төсөв санхүү, банк

2018 оны эхний 12 сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 19657.9 сая төгрөг, гүйцэтгэлээр 18449.7 сая төгрөг болж 93.9 хувийн биелэлттэй байна.

Аймгийн төсвийн нийт зарлагын төлөвлөгөө 17883.0 сая төгрөг, гүйцэтгэлээр 17712.4 сая төгрөг болж 99.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

2018 оны эхний 12 сарын байдлаар авлагын үлдэгдэл 66.8 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 50.6 сая төгрөг байна.

Зураг VI.1. Орон нутгийн төсвийн орлого, зарлага, жил бүрийн эхний 12 сарын байдлаар, сая төгрөгөөр



Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй банкуудын салбарын жилийн эцсийн зарим үзүүлэлтийг танилцуулбал цахим банкны үйлчилгээний хэрэглэгчид давхардсан тоогоор 63.0




мянгад хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 2 дахин их, зээлийн бүтээгдэхүүн давхардсан тоогоор 103 болж өмнөх оны мөн үеэс 2.8 дахин өссөн байна. Давхардсан тоогоор 48 аж ахуйн нэгж байгууллагад 2.3 тэрбум төгрөгийн зээл олгосон нь өмнөх оны мөн үеэс 27.8 хувиар өссөн бол, 8539 иргэнд 29.8 тэрбум төгрөгийн, үүнээс 489 малчинд 1.1 тэрбум төгрөгийн зээл олгосон нь өмнөх оны мөн үеэс иргэдийн зээл 2.9 дахин, малчдын зээл 2.2 дахин буурсан үзүүлэлттэй байна.




VII. Мал аж ахуй, газар тариалан

Аймгийн хэмжээнд 2017 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 201476 хээлтэгч малын 170469 буюу 84.6 хувь нь төллөсөн байна. Төл бойжилт 80.3 хувьтай байна. 2018 оны эхний 12 сарын байдлаар 39535 толгой том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны мөн үеэс 13.7 дахин их байна. Том малын зүй бус хорогдлын 25.6 хувь нь хээлтэгч мал байна.

Зураг VII.1.Төллөсөн хээлтэгч, жил бүрийн эхний 12 сарын байдлаар, толгойгоор




Зураг VII.2.Хорогдсон хээлтэгч, жил бүрийн эхний 12 сарын байдлаар, толгойгоор






2018 онд аймгийн хэмжээнд нийт 40.21 га талбайд төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалсан байна. Тариалсан талбайн мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулбал төмс 1.94 га талбайгаар буюу 11.3 хувиар, хүнсний ногоо 4.26 га талбайгаар буюу 24.7 хувиар буурч, тэжээлийн ургамал 7.7 га талбайгаар буюу 2.8 дахин нэмэгдсэн байна.

Зураг VII.3.Тариалсан талбай, 2018 оны байдлаар, га



Ургац хураалтын эцсийн мэдээгээр аймгийн хэмжээнд 15.23 га талбайгаас 96.67 тн төмс, 12.98 га талбайгаас 130.74 тн хүнсний ногоо, 7 га талбайгаас 42.65 тн тэжээлийн ургамал хураасан нь өмнөх оны мөн үеэс төмс хураалт 3.9 хувиар, хүнсний ногоо 7.1 хувиар буурч, тэжээлийн ургамал хураалт 1.5 дахин нэмэгдсэн байна.

Зураг VII.4.Хураасан ургац, тн



Урьдчилсан байдлаар 4395.8 тн хадлан, 92.7 тн гар тэжээл, 596.1 тн хужир шүү бэлтгэсэн байна.



VIII. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2018 оны эхний 12 сарын байдлаар 48.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.7 тэрбум төгрөг буюу 7.1 хувиар, оны үнээр 53.1 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1.0 тэрбум төгрөг буюу 5.2 хувиар буурсан байна.

Шивээ-Овоо ХК нь нийт бүтээгдэхүүний 93.2 хувь буюу 45.2 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийт борлуулалтын 95.1 хувь буюу 50.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.

Зураг VIII.1. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, салбараар, жил бүрийн эхний 12 сарын байдлаар, сая төгрөгөөр



IX. Цаг агаарын мэдээ 12 дугаар сард:

Хур тундас: 2, 20-ны өдрүүдэд цас орж, нийт 0.3 мм тунадастай.

Салхи: Энэ сард ихэнхи хугацаанд салхи 4-9 м/сек, 2-3-ны өдрүүдэд 10-11 м/сек хүрч ширүүссэн.



Агаарын температур: Агаарын температур 1,2-ний өдрүүдэд шөнөдөө 10-15 градус хүйтэн, өдөртөө 0-5 градус дулаан, 3-11-ний өдрүүдэд шөнөдөө 25-30 градус хүйтэн, өдөртөө 15-20 градус хүйтэн, 12-24-ний өдрүүдэд шөнөдөө 17-22 градус, өдөртөө 5-10 градус хүйтэн, 25-31-ний өдрүүдэд шөнөдөө 2-34 градус хүйтэн, өдөртөө 15-20 градус хүйтэн байсан байна.

НЭГДҮГЭЭР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

Энэ сарын агаарын температурын дундаж нь ихэнх нутгаар 15-20 градус хүйтэн байх ба нийт нутгаар уур амьсгалын дунджаас дулаан байх төлөвтэй. Нэгдүгээр арав хоногийн эхний хагаст шөнөдөө 19-24 градус, өдөртөө 5-10 градус хүйтэн байна. Харин хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн эхний хагаст хүйтний эрч бага зэрэг чангарч шөнөдөө 22-27 градус, өдөртөө 12-17 градус хүйтэн байна. Бусад хугацаанд шөнөдөө 18-23 градус, өдөртөө 7-12 градус хүйтэн байна. Энэ сард Говьсүмбэр аймгийн нутгаар дунджийн орчим цас орох төлөвтэй. Хоёр болон гуравдугаар арав хоногийн дунд үеэр нутгийн зарим газраар цас орж, цасан



шуурга шуурах төлөвтэй. Салхи нэгдүгээр арав хоногийн эхэн болон дунд үеэр ихэнх нутгаар, гуравдугаар арав хоногийн эхэн болон дунд үеэр зарим газраар 12-14 м/с хүртэл ширүүсэх төлөвтэй.





ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 I-XII	2018 I-XII	$\frac{2018 \text{ I} - \text{XII}}{2017 \text{ I} - \text{XII}} \%$
Нийгмийн статистик				
Амьд төрсөн хүүхэд	хүүхэд	418	470	112.4
Ажил хайгч ажилгүй иргэд, сарын эцэст	хүн	284	137	48.2
Халдварт өвчнөөр өвчлөгсөд	хүн	234	262	1119
Бүртгэгдсэн гэмт хэрэг	хүн	171	176	102.9
Эдийн засгийн статистик				
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	15304.5	18449.7	120.6
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	14712.0	17712.4	120.4
Авлага	сая.төг	18.5	66.8	361.1
Өглөг	сая.төг	9.6	50.6	527.1
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	сая.төг	52206.7	48478.9	92.9
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт	сая.төг	54120.5	53134.9	98.2
Төллөсөн хээлтэгч	толгой	171464	170469	99.4
Гарсан төл	толгой	173054	171828	99.3
Хорогдсон төл	толгой	2828	33875	1197.8
Бойжсон төл	толгой	170226	137953	81.0
Том малын зүй бусын хорогдол	толгой	2890	39535	1368.0



I.1 АЖЛЫН БАЙРНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 12 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2017 I-XII	2018 I-XII	$\frac{2018 I - XII}{2017 I - XII} \%$
Ажил хайгч иргэд, сарын эцэст	544	192	35.3
Үүнээс: эмэгтэй	329	100	30.4
Ажил хайгч ажилгүй иргэд, сарын эцэст	284	137	48.2
Үүнээс: эмэгтэй	167	67	40.1
Ажлын байрны захиалга	26	35	134.6
Ажилд зуучлагдсан иргэд	16	28	175.0
Үүнээс: эмэгтэй	7	5	71.4

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээ

I.2 ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2017 I-XII	2018 I-XII	$\frac{2018 I - XII}{2017 I - XII} \%$
Амаржсан эх	394	468	118.8
Төрсөн хүүхэд	400	469	142.3
Үрчлэгдсэн хүүхэд	4	9	225.0
Бүртгүүлсэн гэр бүл	72	86	119.4
Цуцалсан гэр бүл	34	17	50.0
Нас баралт	100	84	84.0
Шилжин ирсэн	641	563	87.8
Шилжин явсан	488	466	95.5

Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээ

II.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Сангийн төрөл	2017 I-XII	2018 I-XII	$\frac{2018 I - XII}{2017 I - XII} \%$
НД-ын сангийн орлого, сая.төг	12 133.7	10 935.5	90.1
НД-ын сангийн зарлага, сая.төг	11 257.8	10 864.7	96.5

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээ



II.2 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮН, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, жил бүрийн эхний 12 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I-XII		2018 I-XII		$\frac{2018 \text{ I} - \text{XII}}{2017 \text{ I} - \text{XII}} \%$	
	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн
Нийгмийн халамжийн сангийн дүн	5 634	1 378.2	7 467	1 973.2	132.5	143.2
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1 317	754.0	2 314	1 200.1	175.7	159.2
Халамжийн тэтгэвэр	264	385.5	270	421.3	102.3	109.3
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	1 053	368.5	2 044	778.7	194.1	211.3
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт тусламж	4 317	624.2	5 153	773.1	119.4	123.9
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	1 147	186.9	2 397	241.7	208.9	129.3
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	355	62.9	314	61.9	88.5	98.4
Нийгмийн халамжийн үйлчилгээ	1 183	64.6	806	99.0	68.1	153.3
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт тусламж мөнгөн тусламж	386	131.0	354	188.6	91.7	144.0
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	5	11.7	6	12.1	120.0	103.4
Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж	1 241	167.0	1 276	169.7	102.8	101.6

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээ



III.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Үзүүлэлт	2017 I-XII	2018 I-XII	$\frac{2018 I - XII}{2017 I - XII} \%$
Төрсөн эх	416	471	113.2
Амьд төрсөн хүүхэд	418	470	112.4
Эрэгтэй	220	230	104.5
Эмэгтэй	198	240	121.2
Амьгүй төрсөн хүүхэд	2	1	50.0
Нийт нас баралт	91	64	70.3
Эмнэлгийн нас баралт	7	9	128.6
Хоног болоогүй нас баралт	5	3	60.0
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	3	1	33.3
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	3	2	66.7
Эмчлэгдсэн өвчтөн	4 852	5 143	106.0
Амбулаторийн үзлэг	115 870	109 970	94.9
Халдварт өвчин	234	262	112.0

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газрын мэдээ

IV.1 ЭРҮҮГИЙН БОЛОН ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН МЭДЭЭ , жил бүрийн эхний 12 сарын байдлаар, төрлөөр

Үзүүлэлт	2017 I-XII	2018 I-XII	$\frac{2018 I - XII}{2017 I - XII} \%$
Бүртгэгдсэн гэмт хэрэг	171	176	102.9
Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг	84	94	92.3
Өмчлөх эрхийн эсрэг	56	52	111.9
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	4	10	250.0
Хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	20	11	55.0
Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг	2	0	*
Авилгын гэмт хэрэг	0	6	*
Бусад гэмт хэрэг	1	0	*



Гэмт хэрэгт <u>холбогдог</u> сод	190	124	65.3
15 хүртэлх насны	6	2	33.3
16-34 насны	110	72	65.5
35 ба түүнээс дээш насны	74	50	67.6
Боловсрол – Дээд	36	22	61.1
Боловсрол - Тусгай дунд	7	8	114.3
Боловсрол – Бүрэн дунд	57	44	77.2
Боловсрол – Бүрэн бус дунд	48	32	66.7
Боловсрол – Бага	19	11	57.9
Боловсролгүй	23	7	30.4
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн	12	29	241.7
Ажилгүй иргэд үйлдсэн	90	65	72.2
Эмэгтэй хүн оролцсон	28	18	64.3
Хүүхэд оролцсон	15	5	33.3
Бүлгээр үйлдсэн	12	8	66.7
Согтуугаар үйлдсэн	56	68	121.4
Гэмт хэргийн гаралт, нөхцөл байдал	171	176	102.9
Гудамж талбайд	49	46	93.9
Гэмт хэргийн улмаас нас барсан	9	5	44.6
Гэмт хэргийн улмаас гэмтсэн	127	107	84.3
Учирсан хохирол / сая.төг /	304.0	548.9	190.4
Нөхөн төлүүлсэн хохирол / сая.төг /	210.0	290.8	138.5

Эх үүсвэр: Цагдаагийн хэлтсийн мэдээ

VI.1 ТӨСВИЙН ОРЛОГО, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 12 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I-XII	2018 I-XII	$\frac{2018 \text{ I} - \text{XII}}{2017 \text{ I} - \text{XII}} \%$
Нийт орлого	15 304 .5	18 449.7	120.6
Урсгал орлого	6 176.5	5 731.6	92.8
Татварын орлого	4 691.8	5 082.2	108.3
Татварын бус орлого	1 484.8	649.4	43.7
Тусламжийн орлого	9 127.9	12 718.1	139.3

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ



VI.2 ТӨСВИЙН ЗАРЛАГА, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 12 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I-XII	2018 I-XII	$\frac{2018 I - XII}{2017 I - XII} \%$
Нийт зарлага	14 712.0	17 712.4	120.4
Урсгал зардал	12 924.8	15 633.4	121.0
Хөрөнгийн зардал	1 787.2	2 079.0	116.3

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

VI.3 ТӨСВИЙН ӨГЛӨГ, АВЛАГЫН ҮЛДЭГДЭЛ, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 12 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I-XII	2018 I-XII	$\frac{2018 I - XII}{2017 I - XII} \%$
Авлага	18.5	66.8	361.1
Өглөг	6.6	50.6	766.7
Төсөвт байгууллагын тоо	49	49	100.0
Төсөвт байгууллагын ажиллагсад	783	783	100.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

VII.1 МАЛ ТӨЛЛӨЛТ, эх малын төрлөөр, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Төрөл	2017 I-XII	2018 I-XII	$\frac{2018 I - XII}{2017 I - XII} \%$
Бүгд	171 464	170 469	99.4
Ингэ	185	244	131.9
Гүү	5 405	4 921	91.0
Үнээ	5 182	5 196	100.3
Эм хонь	85 975	86 186	100.3
Эм ямаа	74 714	73 922	98.9

VII.2 ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ сумдаар, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Сумд	2017 I-XII	2018 I-XII	$\frac{2018 I - XII}{2017 I - XII} \%$
Дүн	171 464	170 469	99.4
<u>Баянтал</u>	25 743	28 862	112.1
Сүмбэр	128 054	123 469	110.3
<u>Шивээговь</u>	17 664	18 138	102.7



VII.3 БОЙЖСОН ТӨЛ, төлийн төрлөөр, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Төрөл	2017 I-XII	2018 I-XII	$\frac{2018 I - XII}{2017 I - XII} \%$
Бүгд	170 226	137 953	81.0
Ботго	177	230	129.9
Унага	5 349	3 979	74.4
Тугал	5 115	4 509	88.2
Хурга	85 559	73 227	85.6
Ишиг	74 026	56 008	75.7

VII.4 БОЙЖСОН ТӨЛ, сумдаар, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Сумд	2017 I-XII	2018 I-XII	$\frac{2018 I - XII}{2017 I - XII} \%$
Дүн	170 226	137 953	81.0
<u>Баянтал</u>	25 857	25 806	99.8
Сүмбэр	126 240	94 336	74.7
<u>Шивээговь</u>	18 129	17 811	98.2

VII.5 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Төрөл	2017 I-XII	2018 I-XII	$\frac{2018 I - XII}{2017 I - XII} \%$
Бүгд	2 890	39 535	1 368.0
Тэмээ	3	11	366.7
Адуу	111	1 796	1 618.0
Үхэр	144	2 071	1 438.2
Хонь	1 095	15 913	1453.2
Ямаа	1 537	19 744	1284.6

VII.6 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Сумд	2017 I-XII	2018 I-XII	$\frac{2018 I - XII}{2017 I - XII} \%$
Дүн	2 890	39 535	1 368.0
<u>Баянтал</u>	312	2 635	844.6
Сүмбэр	2 456	35 968	1464.5
<u>Шивээговь</u>	122	932	763.9



VII.7 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Төрөл	2017 I-XII	2018 I-XII	$\frac{2018 I - XII}{2017 I - XII} \%$
Бүгд	744	10 106	1 358.3
Тэмээ	0	1	*
Адуу	20	441	2 205.0
Үхэр	34	414	1 217.6
Хонь	341	3 636	1 066.3
Ямаа	349	5 614	1 608.6

VII.8 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Сумд	2017 I-XII	2018 I-XII	$\frac{2018 I - XII}{2017 I - XII} \%$
Дүн	744	10 106	1 358.3
<u>Баянтал</u>	34	626	1 841.2
Сүмбэр	660	9 342	1 694.4
<u>Шивээговь</u>	50	138	276.0

VIII.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт жил бүрийн эхний 12 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I-XII	2018 I-XII	$\frac{2018 I - XII}{2017 I - XII} \%$
Нийт	52 206.7	48 478.9	92.9
Нүүрс олборлолт	46 879.7	45 205.9	96.4
Боловсруулах үйлдвэр	2 950.9	462.2	15.7
Цахилгаан,дулааны эрчим хүч	2 376.1	2 810.8	118.3

VIII.2 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, жил бүрийн эхний 12 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I-XII	2018 I-XII	$\frac{2018 I - XII}{2017 I - XII} \%$
Нийт	54 120.5	53 134.9	98.2
Нүүрс борлуулалт	49 245.5	50 456.0	102.5
Боловсруулах үйлдвэр	2 772.7	454.8	16.4
Цахилгаан, дулаан эрчим хүч	2 102.3	2 224.1	105.8



VIII.3 Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үзүүлэлтүүд, Шивээ-Овоо ХК жил бүрийн эхний 12 сарын байдлаар

Үзүүлэлт	2017 I-XII	2018 I-XII	$\frac{2018 \text{ I} - \text{XII}}{2017 \text{ I} - \text{XII}} \%$
Нүүрс борлуулалт /үнийн дүнгээр, сая.төг/	49 245.5	50 456.0	102.5
Нүүрс олборлолт /үнийн дүнгээр, сая.төг/	46 879.7	45 205.9	96.4
Нүүрс гаргалт /биет хэмжээ, мян.тн/	2 074.7	2 000.7	96.4
Ажиллагсад	547	535	97.6

Е-майл хаяг:

govisumber@nso.mn

Вэб хаяг:

govisumber.nso.mn

Мэдээллийн сангийн хаяг:

www.1212.mn

Утас:

70543222, 70543017